



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/334

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа “Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба (П.Ариунгэрэл)-нд, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн үйлчилгээний газар (Э.Төрбаяр), Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг), Захиргаа, хүний нөөцийн газар (Р.Амарбаясгалан), Дотоод хяналтын алба (И.Амарсанаа)-нд тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны А/64 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн
А/334 дүгээр тушаалын хавсралт



НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба (цаашид "НМҮА" гэх) нь ИНД-175 дүрмээр "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага, гэрчилгээжүүлэлт" гэрчилгээжсэн, Агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, тогтмолжилт, үр ашигт шаардлагатай нисэхийн мэдээлэл, нисэхийн өгөгдлийн урсгалаар тасралтгүй хангах нисэхийн мэдээллийн үйлчилгээг үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид "ИНЕГ" гэх)-ын харьяа Иргэний нисэхийн үндэсний төв (цаашид "ИНҮТ" гэх)-ийн салбар нэгж юм.

1.2 НМҮА нь үйл ажиллагаандаа Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Олон улсын нэгдэн орсон гэрээ, дүрэм, хөтөлбөр, олон улсын стандарт, ИНЕГ, ИНҮТ-өөс батлан гаргасан тушаал, шийдвэр, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад эрх зүйн баримт бичиг болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3 Энэхүү журмын зорилго нь НМҮА-ны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, бүтэц, удирдлага зохион байгуулалт, эрх, үүрэг, төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр.Албаны нэр, оршин байгаа хаяг

2.1. Албаны оноосон бүтэн нэр "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба", товчилсон нэр нь "НМҮА" байна.

2.2. НМҮА-ны оршин байгаа газар нь: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа нисэх буудал

2.3. Шуудангийн хаяг: Улаанбаатар 17120, Буянт-Ухаа нисэх буудал, Утас: 976-71283131, Факс: 976-70049838, Цахим шуудангийн хаяг: ais@mcaa.gov.mn

Гурав.НМҮА-ны бэлгэдэл, тамга тэмдэг

3.1. НМҮА нь холбогдох хууль, журам, стандартад нийцсэн хяналтын дугаар бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

3.2. НМҮА нь үйл ажиллагааны онцлог шинж чанарыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байна. Бэлгэдлийн загварыг ИНҮТ-ийн дарга батална.

Дөрөв.Үйл ажиллагааны чиг үүрэг

4.1. НМҮА нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Нисэхийн мэдээллийн эмхэтгэлийн үйлчилгээ үзүүлэх;

4.1.2. NOTAM-н үйлчилгээ үзүүлэх;

4.1.3. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;

4.1.4. Аэродромын нислэгийн хөдөлгөөний мэдээ зохицуулалтын үйлчилгээ үзүүлэх;

4.1.5. Нислэгийн зургийн үйлчилгээ үзүүлэх;

4.1.6. Нисэхийн тоон өгөгдлийн багцын үйлчилгээ үзүүлэх;